



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2021

Э-сонин

07-Р САР

96-р дугаар






Зах зээлийн тойм


/2021.07.30-ны өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр	18
2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/	24,090,709,152.91
Хувьцаа /хоёрдогч/	5460523671.48
Багцын арилжаа	683,821,800
Хөрөнгө оруулалтын сан /хоёрдогч/	123,852,755.43
Компанийн бонд /анхдагч/	5,000,000,000
Компанийн бонд /хоёрдогч/	13,506,332,726
ХБҮЦ /хоёрдогч/	0
3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг	16,344,330
Хувьцаа /хоёрдогч/	15,727,978
Багцын арилжаа	3,419,109
Хөрөнгө оруулалтын сан /хоёрдогч/	514,784
Компанийн бонд /анхдагч/	50,000
Компанийн бонд /хоёрдогч/	51,568
ХБҮЦ /хоёрдогч/	0
4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо	

TOP-20 индекс




MSE B индекс



Зах зээлийн үнэлгээ



MSE A индекс



БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААС

1. Нийт үнэт цаас	185
100% төрийн өмчит	17
Төрийн өмчийн оролцоотой	10
Хувийн өмчийн	158
I ангилал	18
II ангилал	42
III ангилал	125
Компанийн бонд	2
Хөрөнгө оруулалтын сан	1
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	1

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	53
Үүнээс: Брокер, Дилер	53
Андеррайтер	16
Хөрөнгө оруулалтын зөвлөх	14



АРИЛЖААНД ИДЭВХТЭЙ ОРОЛЦСОН ГИШҮҮН ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИУД

/2021.07.30-ны байдлаар/

	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн / авсан, зарсан/ (төг)
		Тоо ширхэг	Үнийн дүн (төг)	Тоо ширхэг	Үнийн дүн (төг)	
1	Лайфтайм инвестмент ҮЦК ХХК	32,317	8,556,368,235.00	37,055	8,548,796,096.00	17,105,164,331.00
2	Өлзий энд КО капитал ҮЦК ХХК	792,182	2,106,737,710.53	1,454,573	5,205,613,771.74	7,312,351,482.27
3	БиДиСек ҮЦК ХК	1,760,584	2,117,244,182.46	2,110,074	3,496,062,278.15	5,613,306,460.61
4	Ти Ди Би Капитал ҮЦК ХХК	1,069,405	3,096,477,008.82	877,044	1,256,812,408.05	4,353,289,416.87
5	Ард секьюритиз ҮЦК ХХК	2,963,662	2,147,244,127.29	2,716,513	1,252,640,927.77	3,399,885,055.06
6	Райнос инвестмент ҮЦК ХХК	1,117,843	2,137,305,514.99	279,128	34,486,158.84	2,171,791,673.83
7	Голомт Капитал ҮЦК ХХК	3,991,064	907,769,193.61	5,364,018	1,121,201,390.27	2,028,970,583.88
8	Таван Богд Капитал ҮЦК ХХК	10,514	1,051,220,870.00	6,671	597,573,985.40	1,648,794,855.40
9	Мандал Капитал Маркетс ҮЦК	0	0.00	133,102	1,045,093,940.00	1,045,093,940.00
10	Бумбат-Алтай ҮЦК ХХК	868,445	493,877,881.48	1,096,832	521,958,337.56	1,015,836,219.04
11	Апекс Капитал ҮЦК	2,271,434	536,360,512.20	430,287	437,945,628.34	974,306,140.54
12	Нэйшил сэкьюритис ҮЦК ХХК	154,457	219,595,420.04	147,713	188,333,848.75	407,929,268.79
13	Стандарт инвестмент ҮЦК ХХК	602,557	195,891,941.74	371,009	117,569,562.17	313,461,503.91
14	Мирэ Эссет Секьюритис Монгол ҮЦК ХХК	20,473	205,020,396.89	49,857	72,052,731.90	277,073,128.79
15	Новел инвестмент ҮЦК ХХК	102,758	138,808,481.47	592,632	47,673,097.11	186,481,578.58
16	Гаули ҮЦК ХХК	96,507	35,132,866.79	104,984	28,887,488.22	64,020,355.01
17	Гүүдсек ҮЦК ХХК	193,144	24,396,460.99	165,182	19,352,231.97	43,748,692.96
18	Аргай бэст ҮЦК ХХК	21,863	26,235,791.03	14,131	10,234,019.00	36,469,810.03
19	Зэргэд ҮЦК ХХК	14,395	27,538,137.92	9,617	3,151,429.20	30,689,567.12
20	Тэнгэр капитал ҮЦК ХХК	23,964	2,512,543.64	74,090	18,010,626.50	20,523,170.14

ИДЭВХТЭЙ АРИЛЖИГДСАН ХУВЬЦАА

/2021.07.30-ны байдлаар/

№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн (төг)	Дээд Ханш	Доод Ханш	Өөрчлөлт %/
1	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК	273,239	2,197,367,220.00	9,495.00	7,300.00	213.46
2	TUM	ТҮМЭН ШУВУУТ ХК	4,263,920	868,383,275.31	230.00	213.11	44.62
3	APU	АПУ ХК	637,464	567,942,959.28	998.00	760.00	1,009.32
4	GOV	ГОВЬ ХК	1,390,023	340,942,278.59	277.00	240.00	191.66
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ ХК	1,206,788	280,746,796.35	248.99	220.00	60.33
6	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ ХК	3,356,593	262,439,306.59	100.00	74.00	56.61
7	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК	65,507	140,298,177.00	2,299.00	1,902.00	80.72
8	AIC	АРД ДААТГАЛ ХК	101,933	136,720,587.00	1,395.00	1,200.00	31.83
9	XOC	ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН	514,784	123,852,755.43	270.00	210.00	11.02
10	LEND	ЛЭНДМН ББСБ ХК	2,102,324	96,815,731.95	47.50	43.00	35.27
11	TCK	ТАЛХ ЧИХЭР ХК	5,824	96,761,160.00	17,050.00	14,490.00	17.45
12	MNP	МОНГОЛ ШУУДАН ХК	55,084	67,923,830.00	1,350.00	1,155.00	117.81
13	TTL	ТАВАН ТОЛГОЙ ХК	8,251	57,762,400.00	7,745.00	6,890.00	369.97
14	ERDN	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН ХК	58,127	53,630,404.30	964.00	880.00	254.46
15	SUU	СҮҮ ХК	178,376	41,152,901.90	245.00	217.00	84.05
16	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ ХК	1,559	37,543,720.00	24,440.00	20,700.00	8.81
17	BUN	БУЛГАН УНДРАГА ХК	165	28,479,600.00	185,000.00	166,000.00	20.26
18	MFC	МОНОС ХҮНС ХК	371,715	24,279,939.32	67.00	64.00	26.58
19	BODI	БОДЬ ДААТГАЛ ХК	180,129	21,731,855.28	125.00	117.00	28.24
20	INV	ИНВЕСКОР ББСБ ХК	6,289	19,884,659.00	3,215.00	3,065.00	230.61



ХАНШИЙН ӨСӨЛТТЭЙ ХУВЬЦАА

/2021.07.30-ны байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (төг)		Ханшийн өөрчлөлт (төг)	Өөрчлөлт /%/
			2021-06-30	2021-07-30		
1	АРИГ ГАЛ ХК	272	2,350.00	2,988.00	638.00	27.15
2	МАНДАЛ ДААТГАЛ ХК	3,356,593	73.40	90.67	17.27	23.53
3	АПУ ХК	637,464	794.33	949.52	155.19	19.54
4	ШАРЫН ГОЛ ХК	1,233	755.00	900.00	145.00	19.21
5	ЖЕНКО ТУР БЮРО ХК	14,799	58.36	69.00	10.64	18.23
6	АВТО ИМПЕКС ХК	23	3,100.00	3,600.00	500.00	16.13
7	МОН-ИТ БУЛИГААР ХК	28	7,300.00	8,395.00	1,095.00	15.00
8	МОНГОЛ ШЕВРО ХК	1	1,800.00	2,070.00	270.00	15.00
9	МЕРЕКС ХК	45,206	26.00	29.90	3.90	15.00
10	ХЭРЛЭН ХИВС ХК	236	42.00	48.30	6.30	15.00
11	ТАВ ХК	5	6,750.00	7,750.00	1,000.00	14.81
12	ЭРДЭНЭС СОЛЫЮШИНС ХК	1,777	103.00	118.00	15.00	14.56
13	ТАЛХ ЧИХЭР ХК	5,824	15,000.00	17,050.00	2,050.00	13.67
14	ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГ ХК	12	361.00	404.00	43.00	11.91
15	НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	26,067	117.00	130.00	13.00	11.11
16	МАТЕРИАЛИМПЕКС ХК	391	6,730.00	7,460.00	730.00	10.85
17	Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК	11,767	95.00	104.90	9.90	10.42
18	ДАРХАН ХӨВӨН ХК	1	10,100.00	11,100.00	1,000.00	9.90
19	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК	65,507	2,097.00	2,298.00	201.00	9.59
20	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН ХК	58,127	885.00	949.89	64.89	7.33

ХАНШИЙН БУУРАЛТТАЙ ХУВЬЦАА

/2021.07.30-ны байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (төг)		Ханшийн өөрчлөлт (төг)	Өөрчлөлт %
			2021-06-30	2021-07-30		
1	МОНГОЛ САВХИ ХК	337	728.99	560.00	-168.99	-23.18
2	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК	273,239	9,385.00	7,460.00	-1,925.00	-20.51
3	УБ-БҮК ХК	6,065	605.00	514.00	-91.00	-15.04
4	АДУУН ЧУЛУУН ХК	1,402	900.00	777.00	-123.00	-13.67
5	РЕМИКОН ХК	152,832	26.99	23.60	-3.39	-12.56
6	АРД ДААТГАЛ ХК	101,933	1,453.00	1,273.00	-180.00	-12.39
7	АРД КРЕДИТ ББСБ ХК	1,206,788	250.00	220.53	-29.47	-11.79
8	АЙТҮҮЛС ХК	171,490	119.26	108.68	-10.58	-8.87
9	ШИВЭЭ ОВОО ХК	3,484	1,740.00	1,600.00	-140.00	-8.05
10	ГЕРМЕС ЦЕНТР ХК	8,570	123.72	114.00	-9.72	-7.86
11	МАХИМПЕКС ХК	514	2,790.00	2,610.00	-180.00	-6.45
12	МОНГОЛ АЛТ ХК	416	12,650.00	12,000.00	-650.00	-5.14
13	СОНСГОЛОН БАРМАТ ХК	10	1,550.00	1,476.00	-74.00	-4.77
14	БИ ДИ СЕК ХК	18,333	1,099.00	1,050.00	-49.00	-4.46
15	ЭРДЭНЭТ ХҮНС ХК	10	3,400.00	3,250.00	-150.00	-4.41



“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК НЬ 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД 1.5 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН АШИГТАЙ АЖИЛЛАЛАА.

Монгол Улсад хөрөнгийн зах зээл үүсч, Монголын хөрөнгийн бирж байгуулагдсаны 30 жилийн ой тохиож буй 2021 онд хөрөнгийн бирж дээр шинээр олон бүтээгдэхүүн гарч, анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаа эрс нэмэгдэж, хөрөнгийн зах зээл идэвхжсэн, мөн биржийн ТОП-20 индекс болон зах зээлийн үнэлгээ түүхэн дээд үзүүлэлтэд хүрсэн зэрэг ололт амжилтуудаар дүүрэн, үйл ажиллагааны өндөр үр ашигтай хагас жил байлаа.

2021 онцлох үйл явдлууд:

Журмын шинэчлэлтүүд:

Зах зээлд арилжигдах бүтээгдэхүүний төрлийг олшруулах замаар хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын багцаа төрөлжүүлэх боломжийг нэмэгдүүлэх, зах зээлийн хөрвөх чадварыг сайжруулах үүднээс Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журмууд, олон улсын жишигт нийцүүлэн ETF буюу биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмын төслийг боловсруулан, холбогдох байгууллагуудаас санал аван ажиллаж байна.

Мөн зах зээлийн эрчимтэй өсөлт, үнэт цаас гаргалт нэмэгдсэнтэй холбогдуулан МХБ-ийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журамд холбогдох өөрчлөлтүүдийг оруулж, батламжлуулсан юм.

Арилжаа:

Дотоодын үнэт цаасны зах зээлийн чиг хандлага, хэмжээг тодорхойлогч гол үзүүлэлт болох ТОП-20 индекс нь 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр 37,973.05 нэгжид хүрч, зах зээлийн үнэлгээ 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдөр 3,804,035,793,516 төгрөгт хүрсэн нь түүхэн дээд үзүүлэлт болсон бөгөөд энэ нь оны эхэнтэй харьцуулахад ТОП 20 индекс 96%, зах зээлийн үнэлгээ 25%-ийн өсөлттэй үзүүлэлт байлаа. Мөн МХБ дээрх үнэт цаасны нийт арилжааны дүн оны эхний хагас жилийн байдлаар 646.7 тэрбум төгрөгт хүрсэн амжилттай байна.

Шинэ бүтээгдэхүүн:

Анхны хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг арилжаалжсан нь олон улсын жишгийн дагуу банк, санхүүгийн байгууллагууд активаа багцлан үнэт цаасжуулж, хөрөнгийн зах зээлд худалдан санхүүжилт татах замаар эрсдэлээ хуваалцах, санхүүгийн байгууллагуудад хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжилтийн шинэ суваг нээгдэх, иргэдэд тогтмол хугацаат хүүгийн орлого бүхий эрсдэл харьцангуй багатай гэх мэт олон давуу тал

бүхий хөрөнгө оруулалтын шинэ бүтээгдэхүүн зах зээлд бий болов.

Тайлант хугацаанд 3 компанийн бонд арилжаалагдаж нийт 360.6 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн бөгөөд МХБ дээрх анхны гадаад валютаар илэрхийлэгдсэн бондыг “Эрдэнэс Таван-толгой” ХК гаргасан нь амжилттай арилжаалагдаж байна.

Мөн зах зээл дээр хоёрдох давхар бүртгэл буюу Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй “Степпе Гоулд” ХК бүртгэгдэж, анхдагч зах зээлийн арилжаа хийгдэхээр товлөгдоод байгаа бол “Мандал ассет менежмент” хамтын хөрөнгө оруулалтын сан бүртгэгдэж, анхдагч зах зээлийн захиалга явагдаж байна.

МХБ-ийн санхүүгийн үр ашиг:

МХБ ТӨХК нь 2021 оны эхний хагас жилд үйл ажиллагаанаас нийт 2.6 тэрбум төгрөгийн орлогыг олж, 1.1 тэрбум төгрөгийн зардлыг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрснөөр 1.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллалаа. Компанийн үйл ажиллагааны жилийн орлогыг 2.7 тэрбум төгрөгт хүргэж, үйл ажиллагааны нийт зардлыг бүрэн нөхөж, борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардлыг 99 мөнгө үзүүлэлтэд хүргэж ажиллахаар 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тусгасан ба энэхүү үзүүлэлт нь эхний хагас жилийн гүйцэтгэлээр 1 төгрөгт 43 мөнгө гэсэн үзүүлэлтэд хүрсэн буюу 57%-аар давж биелсэн үзүүлэлттэй байна.

Мөн тайлант хугацаанд зах зээлийн дэд бүтэц болох МПТ системийн ашиглалттай холбоотой хуримтлагдсан өр төлбөрт 524,000 ам.долларыг төлж барагдуулахын зэрэгцээ зохих хууль, дүрэм, журмын дагуу Улсын төсөвт нийт 296 сая төгрөгийн татвар, шимтгэлийг цаг хугацаанд нь төлж, Улсын төсөв бүрдэлтэд хувь нэмрээ оруулж ажиллалаа.

Ийнхүү өнөөгийн цар тахал, эдийн засгийн хүнд нөхцөл байдлыг үл харгалзан дотоодын хөрөнгийн зах зээл идэвхжиж, шинэ бүтээгдэхүүний тоо нэмэгдсэн ололт амжилтаар дүүрэн байгаа ба цацшид хөрөнгийн зах зээл маань улам хөгжиж, улс орныхоо эдийн засгийн хөгжилд бодит үр дүнгээ өгч, хөгжлийн түүчээ болон өргөжин хөгжинө гэдэгт эргэлзэхгүй байна.



ШАНХАЙН ХӨРӨНГИЙН БИРЖТЭЙ ХАМТРАН МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ СУРТАЛЧЛАХ АРГА ХЭМЖЭЭГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Монголын хөрөнгийн бирж нь дотоодын хөрөнгийн зах зээлд оролцох гадаадын хөрөнгө оруулагчдыг нэмэгдүүлэх зорилгоор зах зээлийг сурталчлах, зах зээлд олон улсын стандартууд нэвтрүүлэх, олон улсын зэрэглэлд багтаах чиглэлээр шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд дэлхийн ТОП-5 хөрөнгийн биржийн нэг болох Шанхайн хөрөнгийн биржтэй хамтын ажиллагаа эхлүүлж, "Монголын хөрөнгийн зах зээлийн өдөрлөг" нээлттэй вебинарыг 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдөр амжилттай зохион байгууллаа.

Уг арга хэмжээг Шанхайн хөрөнгийн биржийн Олон улсын бизнес хариуцсан дэд захирал Фу Хао нээж үг хэлэхдээ "Ойрын хэргийд болох Монгол, Хятад улсууд нь худалдаа, эдийн засгийн нягт харилцаатай улсууд боловч хөрөнгийн зах зээлийн байгууллагууд, мэргэжилтнүүдийг нэгтгэж холбосон энэ төрлийн арга хэмжээг анх удаа зохион байгуулж байна. Энэхүү арга хэмжээ нь цаашидын хоёр зах зээлийн хамтын ажиллагааны суурийг тавьсан түүхэн ач холбогдолтой арга хэмжээ болох бөгөөд арга хэмжээний үр дүнд Монголын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах өргөн боломжуудыг Хятадын хөрөнгийн зах зээлд оролцогчдод таниулах чухал ач холбогдолтой юм" хэмээн онцлон тэмдэглэв.



Арга хэмжээнд Шанхайд төвтэй хөрөнгө оруулалтын сан, үнэт цаасны компаниудын 50 гаруй төлөөлөл оролцсон бол Монголын талаас Монголын хөрөнгийн биржийн төлөөлүүд, Европын сэргээн босголт хөгжлийн банкны Монгол дахь суурин төлөөлөгч Ханнес Такач, "Райнос Инвестмент ҮЦК" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Денис Бэй нар оролцож, Монголын эдийн засаг, хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал, боломж, цаашдын

ҮЙЛ ЯВДАЛ

хөгжлийн талаар танилцуулснаас гадна ирэх онд Банкны тухай хуулийн дагуу IPO хийхээр зорьж буй системийн нөлөө бүхий банкуудын төлөөлөл болох Хаан банк, Худалдаа хөгжлийн банк оролцож үйл ажиллагааныхаа талаар, шинээр үнэт цаас гаргаж буй "Инвескор ББСБ" ХК болон "Мандал ассет менежмент ҮЦК" ХХК нар шинэ үнэт цаасныхаа талаар тус тус танилцууллаа.

Монголын хөрөнгийн бирж нь энэ төрлийн дараагийн арга хэмжээг стратегийн хамтын ажиллагаатай Лондонгийн хөрөнгийн биржтэй хамтран Лондонд төвтэй хөрөнгө оруулагчдад зориулан энэ оны 9 дүгээр сард зохион байгуулахаар ажиллаж байна.

"ЭМ АЙ ЖИ БИ ҮЦК" ХХК-ИЙН ОНООСОН НЭРИЙГ "МАНДАЛ КАПИТАЛ МАРКЕТС ҮЦК" ХХК БОЛГОН ӨӨРЧИЛЛӨӨ

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн № 158 тоот тушаал, Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захиралын 2021 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн А/62 тоот тушаалын дагуу Монголын хөрөнгийн биржид гишүүнчлэлтэй "Эм Ай Жи Би ҮЦК" ХХК оноосон нэрийг "Мандал Капитал Маркетс ҮЦК" ХХК болгон өөрчиллөө.

"ЗЭТ ЖИ БИ ҮЦК" ХХК-ИЙН ОНООСОН НЭРИЙГ "ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК" ХХК БОЛГОН ӨӨРЧИЛЛӨӨ

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн №158 тоот тушаал, Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захиралын 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/60 тоот тушаалын дагуу Монголын хөрөнгийн биржид гишүүнчлэлтэй "Зэт Жи Би ҮЦК" ХХК оноосон нэрийг "Таван богд капитал ҮЦК" ХХК болгон өөрчиллөө.



БҮРТГЭЛТЭЙ КОМПАНИУД ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛНА.

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь бүртгэлтэй хувьцаат компаниудын мэдээллийн ил тод, нээлттэй байдал, үүргийн хэрэгжилт, компанийн засаглалын кодексын хэрэгжилтийг хангуулах зорилгоор бүртгэлтэй компаниудын хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайланг олон нийтэд нээлттэй илтгэл хэлбэрээр танилцуулах ажлыг 6 дахь жилдээ уламжлал болгон зохион байгуулж байна.

Энэхүү үйл ажиллагаанд оролцох сонирхлоо илэрхийлсэн компаниуд дараах урьдчилсан хуваарийн дагуу тайлангаа танилцуулахаар боллоо. Үүнд:

№	Компанийн нэр	Хуваарьт өдөр
1	"Ард Даатгал" ХК	2021.07.27
2	"Бодь Даатгал" ХК	
3	"Ай Түүлс" ХК	2021.07.28
4	"Таван толгой" ХК	
5	"Мандал Даатгал" ХК	
6	"Үндэсний хувьчлалын сан ХХОС" ХХК	2021.07.29
7	"Ард Кредит" ХК	
8	"Талх чихэр" ХК	
9	"Ард Санхүүгийн Нэгдэл" ХК	2021.07.30
10	"АПУ" ХК	2021.08.02
11	"Монгол Базальт" ХК	
12	"Монгол Шуудан" ХК	
13	"Инвескор ББСБ" ХК	
14	"Сүү" ХК	
15	"ЛендМН ББСБ" ХК	2021.08.03
16	"Мик Холдинг" ХК	
17	"Дархан Нэхий" ХК	
18	"Говь" ХК	
19	"Монос Хүнс" ХК	2021.08.17
20	Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн	

ҮЙЛ ЯВДАЛ

Энэ удаагийн арга хэмжээг COVID-19 цар тахлын улмаас цахим хэлбэрээр зохион байгуулах тул нийт мэргэжлийн байгууллагын шинжээчид болон иргэд, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид тус арга хэмжээг Монголын хөрөнгийн биржийн фэйсбүүк хуудас болох <https://www.facebook.com/mongolianstockexchange> хаягаар дамжуулан шууд бичлэг буюу live хэлбэрээр хүлээн авч, сонирхсон асуултаа цахим хэлбэрээр тавих боломжтой юм.

"МАНДАЛ ДААТГАЛ" ХК 2021 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй "Мандал Даатгал" ХК-ийн 2021 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайланг Санхүү хариуцсан захирал Г.Халиунаа олон нийтэд цахимаар танилцууллаа. Тайлант хугацаанд:

- "Мандал Даатгал" ХК-ийн хураамжийн орлого 22.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 10 хувиар өссөнөөр цэвэр ашгийн хэмжээ 3.2 тэрбум төгрөг болж өссөн байна.
- 1.8 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараасан.
- Хүүхдэд зориулсан эрсдэлийн боловсрол олгох сайт нээсэн.

Хүүхдийн гэнэтийн ослын даатгал гаргаснаас гадна "Аялал 360" дотоодын аяллын даатгалын бүтээгдэхүүн шинээр гаргаад байна. "Мандал Даатгал" ХК-ийн нийт хөрөнгө 65.5 тэрбум төгрөгт хүрсэн нь дотоодын даатгалын зах зээлд хөрөнгийн хэмжээгээрээ тэргүүлж байгаагаас гадна нийт хураамжийн орлого болон цэвэр ашгийн хэмжээгээр салбарын компаниудыг тэргүүлж байна.

"АЙ ТҮҮЛС" ХК 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын хөрөнгийн биржийн 2-р ангилалд бүртгэлтэй, мэдээлэл технологийн "Ай түүлс" ХК-ийн 2021 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайланг гүйцэтгэх захирал Б.Тамир олон нийтэд цахимаар танилцууллаа. Тайлант хугацаанд:

- "Ай түүлс" ХК-ийн нийт борлуулалтын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад хувиар 34 хувь



буурч, 924 сая төгрөгт хүрсэн бол цэвэр ашгийн хэмжээ 176 хувь өсч 62.9 сая төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх чиглэлээр cloud.mn платформ дээр ажиллаж байгаа ба хялбар веб угсралтын үйлчилгээг зах зээлд амжилттай нэвтрүүлснээс гадна Wordpress үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

“ТАВАНТОЛГОЙ” ХК 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА



Монголын Хөрөнгийн Бирж (МХБ)-ийн 1-р ангилалд бүртгэлтэй "Тавантолгой" ХК 2021 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайланг эдийн засагч Ч.Төрмандах 2021 оны 7 дугаар сарын 28-ны өдөр танилцууллаа. Тайлант хугацаанд:

- Компани 608.7 мянган тонн нүүрс олборлон, борлуулж, 91.6 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 27.5 хувиар буурсан үзүүлэлт болжээ
- Уул техникийн нөхцлөөс шалтгаалан бүтээгдэхүүний өртөг нэмэгдсэнтэй холбоотойгоор цэвэр ашгийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс буурч 1.9 тэрбум төгрөгт хүрчээ.

Цаашид борлуултын хэмжээг нэмэгдүүлэх, олборлолтын өртгийг бууруулах, тээвэрлэлтийн зардлыг бууруулахаар ажиллаж байна.

“АРД КРЕДИТ ББСБ” ХК 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын Хөрөнгийн Биржийн 2-р ангилалд бүртгэлтэй “Ард Кредит ББСБ” ХК-ийн 2021 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайланг Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн танилцууллаа. Тайлант хугацаанд:

“Ард Кредит ББСБ” ХК-ийн нийт хөрөнгө 69.3 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оныхоос 40 тэрбум төгрөгөөр өссөн ба 9.2 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны орлого олж 4.6 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

- Нийт 1 сая харилцагчтай болсон бөгөөд зээлийн хүү буурч, хэмжээ өслөө.

Мөн Fast Cash White Хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүн гаргасан ба “No One Left Behind, together” төслийг хамтран хэрэгжүүлсэн байна.

“АРД ДААТГАЛ” ХК 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын Хөрөнгийн Бирж (МХБ)-ийн 1-р ангилалд бүртгэлтэй "Ард Даатгал" ХК нь 2021 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа 2021 оны 7 дугаар сарын 27-ны өдөр олон нийтэд танилцууллаа. Тайлант хугацаанд:

- Нийт хөрөнгө өмнөх оныхоос 5.5 тэрбум төгрөгөөр буюу 19 хувиар өсч, 34.3 тэрбум төгрөгт хүрсэн байна.
- 7.4 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлсэн ба цэвэр хураамжийн орлого 6.4 тэрбум төгрөг нь өмнөх оны мөн үеэс 5 орчим хувиар буурсан үзүүлэлттэй байна.
- 6.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан.
- 2020 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэдээ 608 сая төгрөгийн ногдол ашгийг хуваарилсан байна.

Цахимаар даатгалын үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой ДАН СИСТЕМТЭЙ хамтран ажиллах гэрээг байгуулсан ба АРД МЭНД 360 шинэ даатгалын бүтээгдэхүүн гаргасан байна.



"БОДЬ ДААТГАЛ" ХК 2021 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй "Бодь Даатгал" ХК-ийн 2021 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайланг Гүйцэтгэх захирал Б.Золбаяр, Хөрөнгө оруулалт хариуцсан захирал Г.Билгүүн нар цахим сүлжээгээр дамжуулан олон нийтэд танилцууллаа. Тайлант хугацаанд:

- "Бодь Даатгал" ХК-ийн цэвэр хураамжийн орлого 9.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 27.5 хувиар өссөн байна.

- Компани нь борлуулалтын сувгийг нэмэгдүүлж, <https://bodi-insurance.com/> цахим хуудсаар дамжуулан өндөр эрэлттэй 7 төрлийн даатгалын бүтээгдэхүүнийг санал болгож эхлээд байна.

Цаашид технологийн шинэчлэлтийг өргөжүүлж, АХА буюу олон улсын эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг иргэдэд санал болгохоос гадна "Эрхэм", "Шийдэл" зэрэг шинэ бүтээгдэхүүнүүдийг зах зээлд нэвтрүүлэхээр болсон байна.

"МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ" ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ НӨХЦӨЛД ӨӨРЧЛӨЛТ ОРЛОО



"Мандал Ассет Менежмент ҮЦК" ХХК-ийн үүсгэн байгуулсан "Мандал Ирээдүйн Өсөлт" хамтын хөрөнгө оруулалтын сан нь нийт 50 тэрбум (50,000,000,000) хүртлэх төгрөгийн үнийн дүн бүхий нэгж эрхийг бүртгүүлж, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 1/2304 тоот албан бичгээр олгосон зөвшөөрлийн дагуу нэгж эрхийн анхдагч зах зээлийн арилжааг 2021 оны 6-р сарын 30-ны өдрөөс 2021 оны 8 дугаар сарын 10-ны өдөр хүртэлх

Сангийн нэгж эрхийн танилцуулгад заасны дагуу тавин тэрбум (50,000,000,000) хүртэлх хөрөнгийн 47,500,000 ширхэг нэгж эрх буюу 47,500,000,000 (дөчин долоон тэрбум таван зуун сая) төгрөгийн хөрөнгийг олон нийтээс татан төвлөрүүлэх ба үлдэх

2,500,000 ширхэг нэгж эрх буюу 2,500,000,000 (хоёр тэрбум таван зуун сая) төгрөгийн хөрөнгө оруулалтыг үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани болох "Мандал Ассет Менежмент" ХХК-аас оруулах юм.

2021 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар тус сан нь олон нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн 80-аас дээш хувьтай тэнцэх дүн буюу 40 гаруй тэрбум төгрөгийн захиалгыг олон нийтээс хүлээн аваад байна. Арилжааны захиалгын явцыг бодит цагийн горимоор эндээс үзнэ үү.

"Мандал ассет менежмент ҮЦК" ХХК-ийн 2021 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 21/045 тоот албан бичгээр арилжааны нөхцөлд зарим өөрчлөлт оруулах хүсэлтийн дагуу олон нийтийн захиалгын явц 100 хувь буюу 47,500,000,000 (дөчин долоон тэрбум таван зуун сая) төгрөгийн үнийн дүнд хүрсэн тохиолдолд захиалга хүлээн авах үйл ажиллагааг 2021 оны 8 дугаар сарын 10-ны өдрөөс өмнө хааж, захиалга өгсөн хөрөнгө оруулагчдын захиалгыг бүрэн биелүүллээ.

"ЛЭНД БОНД"-ЫН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААГ АМЖИЛТТАЙ БОЛСОНД ТООЦЛОО

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 1/2354 тоот тушаалаар "Лэндмн ББСБ" ХК-ийн шинээр гаргасан "ЛэндМН Бонд"-ийн анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцож, үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрөөс эхлүүлэх зөвшөөрөл олгосон байна. Иймээс хөрөнгө оруулагчид анхдагч зах зээлийн арилжаанаас үлдсэн мөнгийг үнэт цаасны компаниараа дамжуулан буцаан авах эрх үүссэн болно. Харин бондын хоёрдогч зах зээлийн арилжааг "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК дахь хөрөнгө оруулагчдын дансанд бондыг байршуулан холбогдох мэдээллийг солилцсоны дараа 2021 оны 7 дугаар сарын 5-ны өдрөөс эхлүүлэхээр боллоо.



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТҮҮХЭНД 1 ИХ НАЯД ТӨГРӨГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭТЭЙ АНХНЫ КОМПАНИ ТӨРЛӨӨ



Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны I ангилалд бүртгэлтэй "АПУ" ХК-ийн үнэт цаасны зах зээлийн үнэлгээ өнөөдөр **1,009,315,777,973.36** төгрөгт хүрснээр МХБ-д бүртгэлтэй 1 их наяд төгрөгийн үнэлгээтэй анхны компани боллоо.

Монголын хөрөнгийн биржид 1992 онд бүртгэгдсэн "АПУ" ХК-ийн нэгж үнэт цаас 1995 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр үнэт цаасны хоёрдогч зах зээлд 101 төгрөгөөр арилжигдаж эхэлснээр зах зээлийн үнэлгээ 75 сая төгрөгөөр тооцогдож байсан түүхтэй бөгөөд ийнхүү 26 жилийн дараа 1 их наяд төгрөгийн үнэлгээнд хүрсэн нь хөрөнгийн зах зээлийн үр шимийг 9,000 гаруй хувьцаа эзэмшигчдэдээ төдийгүй олон нийтэд харуулсан үйл явдал боллоо.

Хөрөнгийн зах зээлийн түүхэн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж байгаа 97 жилийн түүхтэй, хүнсний салбарын ууган үйлдвэр "АПУ" ХК-ийн нийт хамт олон, хөрөнгө оруулагчид, харилцагчид, хэрэглэгчид, түнш байгууллагууд та бүхэнд баяр хүргэе.

ҮЙЛ ЯВДАЛ

"УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ БОЛНО

"Улсын их дэлгүүр" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 21/12 тоот тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн 10.00 цагт цахим хэлбэрээр зохион байгуулахаар болсон байна.

Хурлын тов: 2021.09.01-ний өдрийн 10.00 цаг

Бүртгэлийн өдөр: 2021.08.17-ны өдөр

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. "Номин Реалтор" ХХК-тай байгуулсан Барилгын ажлын захиалагчийн эрх шилжүүлэх гэрээтэй холбоотой сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийг батлах;
 2. "Номин Реалтор" ХХК-тай байгуулах түрээсийн гэрээтэй холбоотой сонирхлын зөрчилтэй бөгөөд их хэмжээний хэлцлийг батлах;
- "Улсын их дэлгүүр" ХК нь Хаан банкнаас бага хүүтэй зээл авахтай холбоотойгоор "Номин холдинг" ХХК батлан даалт гаргах тул Улсын их дэлгүүрийн барилгыг гуравдагч этгээдэд барьцаалуулах эрхийг "Номин Холдинг" ХХК-д олгох;

Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн: Гүйцэтгэх захирал И.Галбуян, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат, Ахлах нягтлан бодогч Д.Чимгээ

Холбоо барих утасны дугаар: 8988-5120

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН ХӨВИЙН ХАР МОЛИБДЕН - ЗЭСИЙН ТӨСЛИЙН СТРАТЕГИЙН ҮНЭЛГЭЭГ ЭХЛҮҮЛЖ, ХАР МОРЬ ТАЛБАЙН 2-Р УЛИРЛЫН ӨРӨМДЛӨГИЙН ҮР ДҮНГ ТАНИЛЦУУЛСАН БАЙНА

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн нь Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд нээн илрүүлсэн Хар Морь талбайн 2021 оны 2-р улирлын өрөмдлөгийн үр дүнг танилцуулсан байна.

Баян Хөндий алтны ордоос хойш 3.5 км-т орших Хар Морийн Дэл бүсийн өмнө хэсэгт судлын дагуу доош уналттай эрдэсжсэн бүсэд хэд хэдэн цооногт өндөр агуулгатай (≥ 1 г/т алт) эрдэсжилтийг огтолсон бөгөөд энэхүү өндөр агуулга бүхий бүс нь трендийн дагуу 50 метр өргөн, 180 метр суналтай, гүндээ нээлттэй байх магадлалтай байна.



Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Хөндий Алтны Дүүргээс зүүн зүгт 30 км байрлах өөрийн 100 хувь эзэмшлийн Хөвийн Хар молибден-зэсийн төслийн ("Төсөл") стратегийн үнэлгээг эхлүүлээ. Хөвийн Хар тусгай зөвшөөрөл нь 60 жилийн хугацаатай нийт 6041 га талбайг хамардаг бөгөөд ашиглалтын шатанд шилжээгүй байгаа Ази дахь хамгийн том молибден-зэсийн нөөцүүдийн нэг болох Зуун Мод ордыг агуулдагаас гадна зэс, молибденийн хэтийн төлөв бүхий хэд хэдэн талбайг агуулдаг байна.

“Е-МОНИЕ” ХК-ИЙН ОНООСОН НЭРИЙГ “ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП” ХК БОЛГОН ӨӨРЧЛӨЛӨӨ

“Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.10.11 дүгээр заалт, “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 18 дугаар зүйлийн 3 дугаар заалт, “Е-Моние” ХК-ийн 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 21/4 тоот тогтоол болон 2021 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 21/39 тоот албан хүсэлтийг тус тус үндэслэн Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2021 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн А/44 тоот тушаалаар “Е-Моние” хувьцаат компанийн оноосон нэрийг “Тэнгэрлиг медиа групп” хувьцаат компани болгон өөрчлөлөө.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Сүхбаатарын талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747-2129



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN